**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 27-ны өдөр Дугаар А/38 Эрдэнэт

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 2.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Жагсаалт, журам батлах тухай" А/139 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүн амын нас хүйс, эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах салбар дундын ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг эмнэлгийн үндсэн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг алдагдуулахгүйгээр батлагдсан журам, товлолын дагуу зохион байгуулж, сургалт сурталчилгаа, үзлэгийн хамрагдалт, бүртгэл мэдээллийг хугацаанд нь тайлагнаж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулан мэргэжил арга зүйгээр ханган, үзлэгийн хамралт, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /П.Хишгээ /-д даалгасугай

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн /Г.Энхжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ

9043446 2020030036

My doc. EMG-iin dargiin tushaal

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 04 сарын 27..
өдрийн А/38...тоот тушаалын ..2..... хавсралт

## Хүн амын дунд зохион байгуулах нас хүйс, хүйс, эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах салбар дундын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

**Удирдлага төлөвлөлт, үнэлгээний баг**

- Г.Энхжаргал ЭМГ
- П.Хишгээ ЭМГ
- А.Баярхүү ЭМГ
- М.Алтанбек БОЭТ
- Б.Жаргалсайхан ӨАУМХ

**Эмнэлзүйн чанар хяналтын баг**

- Б.Уртнасан ЭМГ
- Г.Оюунтөгс ЭМГ
- Б.Билгүүнээ ЭМГ
- С.Энхмаа БОЭТ
- Д.Эрдэнэтуяа БОЭТ
- Л.Тунгалагтамир БОЭТ

**Нөөц хангалтын баг**

- Н.Чулуун-Эрдэнэ ЭМГ
- О.Анхбаяр ЭМГ
- Б.Бат-Эрдэнэ ЭМГ
- Н.Баасанжаргал БОЭТ
- Н.Амаржаргал БОЭТ
- Б.Батдэлгээн БОЭТ

**Мэдээлэл сургалт, сурталчилгааны баг**

- А.Хонгорзул ЭМГ
- Г.Цолмонхүү ЭМГ
- Ө.Наранзаяа БОЭТ
- Х.Оюун-Эрдэнэ сэтгүүлч

**Мэдээллийн технологи, цахим бүртгэл, мэдээллийн баг**

- Г.Итгэл ЭМГ
- Х.Оюун-Эрдэнэ ЭМГ
- М.Бурмаа БОЭТ
- Б.Нямхүү БОЭТ

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 04 сарын 27
өдрийн А/38 тоот тушаалын 2 хавсралт

9043446 2020030036

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах салбар дундын ажлын хэсгийн бүрэлдэхүүний ажиллах чиг үүрэг

| № | Үйл ажиллагааны чиглэлээр |
|---|---|
| Нэг. Удирдлага төлөвлөлт, үнэлгээний баг | |
| 1 | Үзлэгт хамруулах нэгдсэн төлөвлөгөө,товлолыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг тооцож, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах |
| 2 | Тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлон дээд шатны байгууллагуудад санал тавьж, шийдвэрлүүлэх |
| 3 | ЭМБ-уудын эрт илрүүлэх үзлэгийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмжөөр хангах |
| Хоёр. Эмнэлзүйн чанар хяналтын баг | |
| 1 | Үзлэг, шинжилгээ, оношилгооны чанар, аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, багаж тоног төхөөрөмжийн ариутгал халдваргүйтгэлтэй холбоотой дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, явцын хяналтыг тогтмол хийж, шаардлагатай арга хэмжээг авах, зөвлөмжөөр хангах |
| 2 | Шаардлагатай тохиолдолд явуулын үзлэг оношилгоо, шинжилгээг зохион байгуулах |
| 3 | Үзлэг, шинжилгээ, оношилгоо нь үндсэн тусламж үйлчилгээний чанар хүртээмжид сөргөөр нөлөөлж буйд үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангах |
| Гурав. Нөөц хангалтын баг | |
| 1 | Үзлэг, шинжилгээ, оношилгоод шаардагдах хүний нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулах, арга зүйн сургалтад эмч, мэргэжилтнүүдийг бүрэн хамруулах, ажлын цагийн болон амралтын хуваарийн зохицуулалтыг хийх |
| 2 | Үзлэг оношилгоонд шаардлагатай өрөө тасалгаа, багаж тоног төхөөрөмж, урвалж бодисын хангамж хэрэгцээг тогтоож, бэлэн байдлыг хангуулах, нөөцийн орлого, зарлагыг burtgel.mohs.mn системд тогтмол оруулж, сар тутам танилцуулж ажиллах |
| 3 | Шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийг Засаг даргад санал тавьж шийдвэрлүүлэх |
| Дөрөв. Мэдээлэл сургалт сурталчилгааны баг | |
| 1 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зохион байгуулалт, ач холбогдлын талаар мэдээлэл сурталчилгаа хийх |
| 2 | Үзлэгийн явц, мэдээллийг нээлттэй байдлаар сурталчлах |
| 3 | Зурагт хуудас, баннер, гарын авлага хэвлүүлэн түгээх |
| Тав. Мэдээллийн технологи, цахим бүртгэл, мэдээллийн баг | |
| 1 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний мэдээ, мэдээллийн шуурхай байдлыг хангаж, тайлан мэдээг нэгтгэн, холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлэх |
| 2 | Цахим системийн бэлэн байдал, ашиглалт, интернетийн хурд, тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангах талаар мэргэжил арга зүй, зөвлөмжөөр хангах |

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 04 сарын 27
өдрийн А/32 тоот тушаалын III хавсралт

9043446 2020030036

Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгооны ерөнхий зураглал

